



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 05

Мандалговь

Хөрөнгө бэлтгэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Ахмадын хороонд өөрийн хөрөнгөөр 1,400,000 /нэг сая дөрвөн зуун мянга/ төгрөгт багтаан суурин компьютер бэлтгэхийг зөвшөөрсүгэй.

2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг Ахмадын хорооны дарга Г.Цэрэндоржид даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100008